



ISO МЕНЕЖМЕНТИЙН СТАНДАРТУУД НЬ МОНГОЛ УЛСЫН ИРЭЭДҮЙГ ТОДОРХОЙЛОХ ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛҮҮДИЙН НЭГ МӨН

Стандартууд тухайн орны үйлдвэрлэл, худалдааг олон улсын зах зээлд нэвтрэх боломжоор хангадаг

Олон улсын менежментийн буюу удирдлагын тогтолцооны стандартууд нь Британы стандартын байгууллагаас (BSI) гаргасан стандартууд байдаг. BSI нь 1946 онд Олон улсын стандартын байгууллага болох ISO-г үүсгэн байгуулснаар эдгээр стандартууд одоо ISO нэртэй болсон юм.

Төрийн, хувийн ямар ч байгууллага өөрийн менежментийн тогтолцоонд эдгээр стандартуудыг нэвтрүүлснээр дэлхийн түвшний менежменттэй болж, дэлхийн аль ч байгууллагатай нэгэн түвшинд, нэг хэлээр ярьж ажил хэргээ бүрэн ойлголцох боломжтой болно. Тиймээс, BSI хэмээх дэлхийн домогт, ууган, хамгийн нэр хүндтэй стандартын байгууллага Монголд орж ирснээр нэгд, Монгол улсын Засгийн газар, төрийн яамдуудад олон улсын менежментийн стандартыг нэвтрүүлж, баталгаажуулах, хоёрт, хувийн хэвшлийн компаниудын менежментийг дэлхийн стандартын түвшинд гаргаж, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлснээр Монгол улсын эдийн засгийг хурдацтай хөгжүүлэх суурийг бэхжүүлж дэлхийн олон нийтэд Монголын бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэж, Монгол улсын нэр хүндийг дэлхийн тавцан дээр улам бүр өсгөх боломж нь хангагдах юм. Тиймээс бид ISO удирдлагын стандартуудыг Монгол улсын дэлхийд гарах гарц, Монгол улсын ирээдүйг тодорхойлох хүчин зүйл, Монгол улсыг эдийн засгийн хямралаас гаргах арга зам гэж харж байна.

BSI 1901 онд байгуулагдсан ба өнөө үед орчин үеийн стандартуудыг зохиох, сайжруулах, тэдгээрийн сургалтууд болон баталгаажуулалтыг зохион байгуулах салбарт дэлхийн хөгжлийн хандлагыг тодорхойлж байна.

BSI нь стандартын ууган байгууллагын хувьд ISO 9001, ISO 14001, OHSAS 18001, ISO 22000, ISO 27001 зэрэг 35,000 түгээмэл стандартуудын зохиогч нь ба одоо ч

тэдгээрийн өөрчлөлт шинэчлэлтэд нь манлайлан оролцсоор байгаа юм.

Монгол улсад стандартын томоохон байгууллагын хувьд BSI нь Стандарт хэмжил зүйн газрын чадавхийг нэмэгдүүлж бэхжүүлэх Европын Холбооны гурван жилийн хугацаатай төслийг 3 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

Бидний үйл ажиллагаа:

1. BSI Академийн модулиудаар бүх төрлийн түгээмэл стандартуудын дөрвөн шатны сургалтуудыг олон нийтэд болон байгууллагууд дээр амжилттай зохион байгуулж байна
2. BSI-ийн ACP (Associated Consultants Program, www.bsigroup.com/MN-mn/)-д бүртгэлтэй олон улсын шилдэг зөвлөх байгууллагуудаар ISO стандартуудыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээг хүргэж байна
3. Стандартын баталгаажуулалтын аудитыг гүйцэтгэж олон улсад бүртгэлтэй гэрчилгээ олгож байна

Олон нийтийн ба байгууллага дээр явуулдаг дөрвөн шатны сургалтууд нь:

1. Тухайн стандартын шаардлагуудын сургалт
2. Тухайн стандартыг байгууллага дээрээ хэрэгжүүлэх арга техникийн сургалт
3. Тухайн стандартын дотоод аудиторуудыг байгууллагын ажилтнуудаас бэлтгэх сургалт
4. Шаардлагатай бол тухайн стандартын олон улсын ахлах аудитор эсвэл ахлах хэрэгжүүлэгч бэлтгэх сургалтууд байдаг

Дээрхээс гадна тухайн байгууллагын журамууд дээр үндэслэсэн сургалт болон гадаадын орнуудад өөрийн салбарын стандарт хэрэгжүүлсэн ижил төрлийн байгууллагаас туршлага судлах тур сургалтуудыг зохион байгуулж байна.

BSI нь ийнхүү стандартыг зохион бүтээж, дэлхий нийтдээ хуваалцаж, байгууллагуудад нэвтрүүлж баталгаажуулалт олгодог бүтэн циклийн иж бүрэн үйлчилгээ хүргэдэг ба үргэлжлүүлэн тухайн байгууллагаа тасралтгүй сайжрахад бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлдэг “эхнээс нь дуустал” шийдэлтэй “төгс төгөлдрийг дадал болгох” уриатай байгууллага юм.

Манай гэрчилгээ Олон улсын итгэмжлэлийн байгууллага International Accreditation Forum (IAF) ба ANU, Их британы байгууллагуудын итгэмжлэлтэй. Мөн BSI-ийн бусад баталгаажуулалтын байгууллагуудаас ялгарах бас нэг онцлог нь BSI нь олон улсын стандартын байгууллагын

хувьд мөн итгэмжлэлийн эрхтэй байдаг нь гэрчилгээн дээрх BSI-ийн итгэмжлэлийн тэмдгээр илэрхийлэгддэг.

BSI нь баталгаажилтын салбартаа тэргүүлэгч компани ба энэ салбарын хөгжлийг тодорхойлогч нь юм. Баталгаажилтын байгууллагын ангиллын хувьд BSI нь “premium class” буюу “дээд зэрэглэлийн” ангилалд ордог.

BSI-ийн нэр хүндийн бас нэгэн баталгаа нь хөрөнгийн биржууд дээрх компаниудын баталгаажуулалтаар илэрдэг. Дэлхийн томоохон хөрөнгийн биржууд дээр бүртгэлтэй компаниудын дийлэнх нь BSI-аар баталгаажуулсан байдаг.

BSI нь Английн хатан хааны зарлигаар байгуулагдсан ашгийн төлөө бус байгууллага тул сургалт баталгаажилтын үнэ нь туйлын өрсөлдөхүйц байдаг зэрэг олон давуу талуудтай.

2015 оноос эхлэн ISO стандартуудад томоохон өөрчлөлтүүд орж байгаа ба эдгээр өөрчлөлтөнд бүх ISO стандартууд хамрагдах юм. Үүний үр дүнд хэрэглэгч та бүхний хувьд дараахь давуу талууд бий болно:

1. Бүх стандартууд ижил бүтэцтэй, ижил нэр томъёо, ижил тодорхойлолтуудтай, бүгд ижил 10 бүлэгтэй болж байгаа. Бүх стандартууд ижил суурьтай болж байгаа нь ISO 9001:2015 стандарт ба энэ суурь нь бусад стандартуудын 40-50 хувийг эзлэх юм.
2. Үүний үр дүнд олон стандартуудыг зэрэг хэрэгжүүлэхэд бүгдээс нь ижил суурь болох 50%-ийг хэрэгжүүлэх цаг хугацаа, нөөцүүд, хүн хүч зэрэг асар их хэмнэлтүүд гарна. Мөн энэ хэмжээгээр тухайн стандартыг хэрэгжүүлэх зардал буюу баталгаажуулалт, зөвлөх үйлчлэгчнүүдийн үнэ нь хямдарч байгаа зэрэг томоохон эерэг өөрчлөлтүүд гарч байна.

Та бүхэн мөн өөрийн байгууллага дээр хэрэгжүүлэхээр зорьж байгаа стандартуудын талаар байгууллага дээрээ үнэ төлбөргүй сургалт, зөвлөгөө авах боломжтой.

BSI-ийн Монголыг хариуцсан ажилтан

Баттогтох овогтой Ундарлаа

Австралийн Үндэсний Их сургуульд эдийн засгийн бодлого боловсруулагчаар бэлтгэгдэж магистр цол хамгаалсан, UNDP-ийн “Үйлдвэрийн газруудыг өөрчлөн байгуулах” төсөл, GIZ-ийн “Хувийн хэвшлийг хөгжүүлэх” төсөл болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкны менежментийн ахлах зөвлөхөөр 2000-2014 онуудад ажиллаж байгаад 2015 оны 11 сараас BSI-ийн Монгол дахь төлөөлөгчөөр ажиллаж байна.